

УЛС ТӨР, ҮЗЭЛ СУРТАЛ

Д. Чулуундаваа

**УЛС ТҮМНИЙ ЭНХ ТАЙВАН, АЮУЛГҮЙ
БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ТҮҮХЭН ШИНЭ ЗОРИЛТ**

Социализмын ууган орны нийслэл Москва хотноо саяхан хуралдсан аугаа их Лениний коммунистуудын дээд чуулга ЗХУКН-ын ээлжит XXVI их хурал дэлхий нийтийн анхаарлыг гойд татсан эрин үеийн улс төрийн гарамгай чухал үйл явдал болов. Энэ түүхт их хурал нэг талаас ЗХУКН-ын XXIV, XXV их хурлуудаас дэвшүүлсэн энх тайвны түүхэн программ хэрэгжин биелж олон улсын хурцадмал байдал улам бүр намжиж, нийгмийн өөр өөр байгуулалтай улс гүрнүүд энх тайвнаар зэрэгцэн орших зарчим олон улсын харилцааны чухал хэм хэмжээ болж, колоничлол, шинэ колоничлолын дарангуйлал мөхөн бөхөж, үндэсний чөлөөлөх хөдөлгөөн идэвхжин өрнөсөн, нөгөө талаас энх тайван, намжмал байдалд заналхийлэх, улс түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөөний тэмцлийг нухчин дарах, зэвсэглэлээр хөөцөлдөхийг улам дэвэргэх, хүчээр түрэмгийлж, бусдын хэрэгт хөндлөнгөөс оролцох, цөмийн дайны аюулыг бий болгох гэсэн хоёр системийн тэмцлийн эрин үед хуралдав.

ЗХУКН ын XXVI их хурал нам, ард түмний сүүлийн 5 жилд хийж гүйцэтгэсэн нөр их ажлын дүнг гаргаж, ойрын ирээдүйд хэрэгжүүлэх намын дотоод, гадаад бодлогын улс төрийн чиг шугам, шинжлэх ухааны үндэстэй программ, зорилтуудыг боловсруулж дэвшүүлэн тавив. Энэ бүхэн нь нөхөр Л.И.Брежневийн тавьсан Намын Төв Хорооны тайлан илтгэл, их хурлаар баталсан ЗСБНХУ-ын эдийн засаг, нийгмийг 1981-1985 онд болон 1990 он хүртэл хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэл, бусад баримт бичигт яруу тод тусгагджээ.

Суут Лениний намын дээд чуулгын индэр дээрээс дэлхий даяарт цуурайтсан үг бүр, баримт бичгийн үзэл санаа дэлхийн олон нийтэд маш их сэтгэгдэл төрүүлж, өргөн олны сонирхлыг дээд хэмжээгээр татаж байна. ЗХУКН, Зөвлөлт орны цаашдын хөгжил түүний нийгэм, эдийн засаг, улс төрийн бодлогыг дэлхий дахинаа ийнхүү өргөнөөр анхааран ширтэж байгаагийн учир нь өнөөгийн хүн төрөлхтний ирээдүй, тэдний хувь заяа Октябрийн хувьсгалын өлгий, аугаа их Зөвлөлт оронтой шууд холбоотой байгаад оршино.

МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю.Цэдэнбал ЗХУКН-ын XXVI их хуралд тавьсан тайлан илтгэлийн тухай хэлэхдээ, «ЗХУКН-ын Төв Хорооны тайлан бол бүтээлч марксизм-ленинизмын гарамгай баримт бичиг юм. Энэ баримт бичиг шинжлэх ухааны коммунизмын онол, практикт шинэ хувь нэмэр боллоо. Коммунист байгууллагыг удирдах энх тайван, бүх нийтийн аюулгүй байдлыг бэхжүүлэх талаар Лениний нам, түүний Төв Хорооны гүйцэтгэсэн олон талт, үр бүтээлтэй гарамгай үйл ажиллагааг тайлан илтгэлд тусган харуулжээ» гэсэн юм.

ЗХУКН-ын XXIV, XXV их хурлаас дэвшүүлэн тавьсан энх тайвны түүхэн программ амжилттай хэрэгжин биелж өнөө үед дэлхий ертөнцийн

байдал эрс өөр болсныг дэлхийн сая сая хүн ард ЗХУКН, Зөвлөлт төрийн бодлоготой холбон үзэж, түүнийг ойлгон, сайшаан дэмжиж байна. Энэхүү программ, бодлогын чиг шугамыг ЗХУ улам бүр гүнзгийрүүлэн бататгаж, цаашид тавих зорилтыг жинхэнэ марксист-ленинист үзэл, хүнлэг бодлын үүднээс дайн түрэмгийллийн хүчийг хазаарлан барьж, бүх нийтийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлж, улс түмний эрх чөлөө, тусгаар тогтнол, нийгмийн дэвшлийг хангах шийдвэр төгс байгааг тус их хурлын шийдвэр нотлон харуулав.

ЗХУКН орчин үеийн олон улсын байдлын тодорхой нөхцөлийг тун нарийвчлан дүгнэн шинжилж үзээд даян дэлхийн энх тайвныг бэхжүүлэх, улс түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөөний цаашдын тэмцлийн талаар онц чухал шинэ зорилтуудыг дэвшүүлж тавилаа. Эдгээр зорилт нь ЗХУКН-аас урьд өмнө дэвшүүлсэн энх тайвны программын шууд үргэлжлэл бөгөөд энх амгалан, аюулгүй байдлыг бэхжүүлэх үйлсэд үнэт хувь нэмэр оруулах шинэ алхам болж байна.

Үүнд нэн түрүүн нийгмийн дэвшлийн тэргүүн манлай ах дүү социалист орнуудын нэгдэл нягтралыг цуцалтгүй бэхжүүлж, тэдний бүх талын нягт хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлэн, энх тайвныг бэхжүүлэх үйлсэд социалист орнуудын идэвхтэй хувь нэмрийг нэмэгдүүлэхийг чухлыг заав. Улмаар олон улсын харилцаанд гарсан нааштай алхам хандлагыг цаашид бэхжүүлж эргэлт буцалтгүй болгох, цэрэг дайны зардал, зэвсэглэлийг хорогдуулах, хүнийг үй олноор устгах цөмийн дайны аюулаас сэрэмжлэх, дайны голомтыг устгах, маргаантай асуудлыг эв зүйгээр зохицуулан шийдвэрлэх, нийгмийн янз бүрийн байгуулал бухий улс орнууд энх тайвнаар зэрэгцэн орших ленинч зарчмын үндсэн дээр олон улсын бүх талын хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг олон чухал хойшлуулшгүй зорилтыг тус их хурал дэвшүүлэн тавьсан нь бүх хүн төрөлхтний эрх ашигт чухамдаа бүрэн нийцэж байгаа юм.

ЗХУКН-ын ленинч гадаад бодлогын бодит практик үйл ажиллагааны шинэ зорилтуудыг шийдвэрлэх явдал нь улс түмний энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлж, бүх хүн төрөлхтний нийгмийн дэвшлийг цаашид түргэтгэхэд таатай нөхцөлийг лавшруулах онцгой чухал ач холбогдолтой юм.

Сүүлийн үед империалист харгис хүчний балмад явууллага, бээжингийн эрх баригч бүлгийн дэлхийг жанжлан эзлэх түрэмгий санаархлын улмаас олон улсын түгшүүртэй байдал дахин хурцдаж даян дэлхийн энх тайванд нэн аюултай хор уршиг тарьж байна. Вашингтоны шинэ засаг захиргаа өөрийн гар хөл бологч НАТО-гийн эвслийн харгис бүлгийнхнийг ташуурдан тухирч, хятадын жанжлах бодлоготнуудтай сүлбээлдэн Зүүн өмнөд Азид энх тайван, тогтвортой байдлыг алдагдуулах, социалист Вьетнам, Лаос, Кампучийн эсрэг илт өдөөн хатгалгаа идэвхжүүлэх, Афганистаны хувьсгалыг багалзуурдан дарах, Ойрхи Дорнодын хямралыг улам дэвэргэх, бүрэн эрхт, тусгаар тогтносон улсуудын дотоод хэрэгт хөндлөнгөөс ичгүүр сонжуургүй оролцох, тэдний уугуул газар нутагт шунан өнгөлзөх зэрэг овилгогүй бодлогоо хэрэгжүүлэхийг махран оролдож байна. Үүний зэрэгцээ зэвсэглэлээр хөөцөлдөхийг улам гааруулах, улмаар дэлхийн хоёр системийн хоорондын цэрэг-стратегийн тэнцүү байдлыг алдагдуулж, цэргийн хүчээр давамгайлах, дунд зайны тусгалтай пуужинт цөмийн зэвсгийг ЗХУ-ын эсрэг Европд байрлуулах, америкийн «тэргүүн байрлалын» цөмийн цохилтын хүчийг бий болгох, цэргийн «буухиа» хүчийг газар сайгүй өөрийн «амин чухал эрх ашгийн» бүсүүд гэгчид тараан цацах зэрэг нэг үгээр хэлэхэд хүчээр далайлган сүрдүүлэх арга мэхдээ ихээхэн «найдвар» тавьж байна.

Гэвч дэлхийн хөгжлийг империализм хянаж байсан үе нэгэнт эгнэгт өнгөрчээ. Дэлхийн социализмын хүч чадал батжин бэхжиж, түүний хүнлэг ариун үйлсийн үзэл санаа хүн төрөлхтний оюун ухаанд баттай нэвтэрч, дайныг эсэргүүцэгч сая живаа хүн энх амгалан байдлын нэвтэршгүй бат цайзыг байгуулав. Социализмын орнуудын цэрэг, улс төрийн холбоо Варшавын Гэрээний байгууллага даян дэлхийн энхийн манаанд бат найдвартай зогсож байна.

Социалист хамтын нөхөрлөлийг дотроос нь хагалан бутаргах империалист харгис хүчний зүсэн бүрийн оролдлого тухай бүр шийдвэртэй цохилт хүлээж байгаагийн сүүлчийн жишээ Польшийн асуудал болов. Улс орны нийгэм, эдийн засгийн дотоод бодлогын зарим дутагдал, доголдлыг сүржигнэн ашиглаж, түүнийг олон улсын тулгамдмал бусад асуудал, үйл явдалтай «холбож» үзэх, үнэн хэрэгтээ социализмын эсрэг бодлогондоо нийцүүлэхийг оролддог империалист хүчний арга мэх аль хэдийнээ тодорхой болсон юм. Вашингтоны шинэ засаг захиргаа «Афганистан дахь зөвлөлтийн түрэмгийлэл», «олон улсын аллага хядлага», «хүний эрхийн төлөө тэмцэл», «Зүүн өмнөд Ази дахь коммунизм, Зөвлөлт, Вьетнамын аюул», «Польш дахь ардчилалыг хамгаалах асуудал» гэх зэрэг бодит үнэнийг мушгин гуйвуулсан элдэв янзын нэр томъёолол, номлол сэдэн гаргаж, түүгээрээ түрээ барьж, дайны голомтыг буй болгох аюултай бодлого, чиг шугамаасаа дэлхий нийтийн анхаарлыг хөндийрүүлэхийг оролдож байгаа нь хий хоосон санаархал мөн. «Польшийн коммунистууд, польшийн ажилчин анги, тус орны хөдөлмөрчид өөрсдийн анд найз, холбоотнуудад бат найдаж болох бөгөөд социалист Польш, ах дүү Польшийг бид хэцүү цагт нь орхихгүй, бусдад доромжлуулахгүй» гэсэн эрс шийдэмгий, цогтой халуун сэтгэлийн үг их хурлын индэр дээрээс дэлхий дахинаа цуурайтсан билээ. Энэ үг Афганистаны ардчилсан хувьсгалд ч хамаарч байгааг хэн бүхэн мэднэ.

ЗХУКН-ын XXIV, XXV их хурлаас дэвшүүлсэн гадаад бодлогын зорилгод БНХАУ-тай сайн хөршийн харилцааг хөгжүүлэхэд бэлэн байгаагаа тодорхойлсон зарчимч байр суурийг XXVI их хурал дахин нотолж империалист харгис хүчинтэй сүлбээлдэн олон улсын түгшүүртэй байдлыг хурцатгах чиг шугам баримталсаар байгаа Бээжингийн чиг бодлогын эсрэг сайн санааны үүднээс нэн тэвчээртэй уян хатан, энхийг эрхэмлэсэн бодлого тууштай баримталж байгаад нь дэлхийн олон нийт ЗХУКН-д нэн талархалтай хандаж байна. ЗХУ нь БНХАУ-тай сөргөлдөхийг хэзээ ч хүсээгүй бөгөөд сөргөлдөх ч санаагүй байгаагаа дахин илэрхийлэв. Эцсийн эцэст энэ нь хятадын ард түмний амин чухал эрх ашигт энх тайвны бодлого, бусад улс оронтой хэвийн харилцаатай байх бодлого л нийцэх нь тодорхой гэдгийг л нотолж байгаа хэрэг.

Капитализмын орнуудтай энх тайвнаар зэрэгцэн орших ленинч түгээмэл зарчмын үндсэн дээр хэвийн харилцааг хөгжүүлж, харилцан ашигтай хамтын ажиллагааг эдийн засаг, шинжлэх ухаан, соёлын салбарт хөгжүүлэх чин эрмэлзэл дүүрэн байгаагаа лениний намын дээд чуулга уулзалт нэр төртэй илэрхийлэхийн хамт даян дэлхийн энх тайванд занал учруулахуйц аливаа оролдлого, түрэмгийлэлд эрс хатуу няцаалт өгөх шийдвэр төгс байгаагаа мэдэгдэв.

Олон улсын байдалд чухал үүрэг хүлээснийг нь нийт даяар хүлээн зөвшөөрч байгаа ЗСБНХУ, АНУ-ын харилцааны талаар зарчимч, үр бүтээлч саналыг зөвлөлт засгийн газар дахин дэвшүүлэв. ЗХУ, АНУ-ын хооронд хамгийн дээд хэмжээнд хүртэл уулзалт хийж, дэлхий нийтийн анхаарлын төвд байгаа амин чухал асуудлуудыг бүхэлд нь авч, идэвхтэй хэлэлцэхэд бэлхэн байгаагаа ЗХУ илэрхийллээ.

ЗХУ, АНУ болон Варшавын Гэрээ, НАТО-гийн хоорондын цэрэг-стратегийн хүч тэнцвэртэй байгаа байдал манай гариг дээр энх тайвныг сахин хамгаалах бодит хүчин зүйл болж байгаа юм. ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга А.И. Брежнев их хуралд тавьсан Төв Хорооны тайлан илтгэлд дурдахдаа, «Бид нөгөө этгээдээс цэргийн хувьд давуутай болохыг хичээгээгүй, хичээх ч үгүй. Энэ бол манай бодлого биш. Гэвч бид бас бусдыг өөрсдөөсөө тийм давуу хүчтэй болгоход хүргэхгүй. Тиймэрхүү оролдлого хийх, түүнчлэн бидэнтэй хүчээр түрээ барих байр сууринаас ярих гэвэл огтхон ч явуургүй юм» гэж тов тодорхой мэдэгдсэн билээ.

ЗХУКН-ын XXVI их хурлаас дэвшүүлсэн энх тайванч дорвнтой шинэ саналуудын дотор цэргийн салбарын итгэлцлийн арга хэмжээг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн бүсийг өргөтгөх, Европ болон дэлхийн бусад хэд хэдэн бүс нутагт уг арга хэмжээг хамруулах санал дэвшүүлсэн нь дэлхий нийтийн сонирхлыг зүй ёсоор татаж байна. Тухайлбал цэргийн салбарт итгэлийг бэхжүүлэх талаар авч явуулж байгаа арга хэмжээг ЗСБНХУ, Хятад, Япон зэрэг орнууд хөрш оршдог, америкийн цэргийн баазууд байгаа Алс Дорнодод хамруулах талаар сонирхогч бүх оронтой тодорхой хэлэлцээ хийхэд ЗХУ бэлэн байгааг их хурлаас нотлов.

Стратегийн зэвсэглэлийг хязгаарлах, түүнийг хорогдуулах асуудал онцгой ач холбогдолтойг их хурлаас заан тэмдэглээд өнөөг хүртэл энэ салбарт асар их хүч чармайлт гаргаж байж хийсэн нааштай бүх зүйлийг хэвээр хадгалан, энэ талаар АНУ-тай зохих хэлэлцээг даруй сэргээн үргэлжлүүлэхэд бэлхэн байгаагаа ЗХУ-ын засгийн газар мэдэгдэв. Чингэхдээ хэлэлцээг зөвхөн тэгш эрх, адилхан аюулгүй байх үндсэн дээр, аль нэг талдаа давуу байдал олгохгүйгээр явуулах бөгөөд тийм хэлэлцээнд зохих үед цөмийн зэвсэгтэй бусад бүх гүрэн ч оролцох ёстойг цохон тэмдэглэсэн байна.

Улмаар ЗХУ ямар ч төрлийн зэвсэглэлийг хорогдуулах тухай хэлэлцээ хийхэд бэлхэн байгаагаа мэдэгдэж, одоо АНУ-д бий болоод байгаа «Трайидент-1» пуужинтай «Огайо» маягийн, түүний эсрэг ЗХУ-д бий болсон мөн тиймэрхүү шинэ шумбагч хөлөг онгоц хийхийг хязгаарлах, Европа НАТО-гийн орнууд болон ЗХУ-ын дунд зайн тусгалтай пуужинт-цөмийн хэрэгсэл байрлуулахыг азнах тухай, энэ бүс нутагт байгаа АНУ-ын тэргүүн байрлалын цөмийн хэрэгслийг оролцуулан ийм хэрэгслийн одоо байгаа хэмжээг тоо чанарын хувьд аль ч талаар нэмэгдүүлэхгүй байх тухай хэлэлцээ хийх жинхэнэ практик ач холбогдолтой тодорхой санал дэвшүүлэн тавив.

Нөхөр Л.И.Брежневийн дэвшүүлсэн Аюулгүйн Зөвлөлийн гишүүн орнуудын дээд хэмжээний удирдагчдыг оролцуулсан Аюулгүйн Зөвлөлийн тусгай хуралдааныг зарлан хуралдуулах, цөмийн сүйрлийг сэрэмжлэн зайлуулахын амин чухлыг улс түмэнд үнэн мөнөөр харуулахуйц олон улсын нэр хүндтэй хороо байгуулах санал нь тив дэлхийн өргөн олон нийтийн анхаарлыг гойд татаж, сайшаагдан дэмжигдэж байна.

ЗХУКН-ын яруу алдарт XXVI их хурлаас дэвшүүлсэн энх тайвны түүхэн шинэ зорилтууд хүн нийгмийн эрх ашигт нийцсэн бүхий л асуудлыг оруулж, тэдгээрийг хэрэгжүүлэх практик арга хэмжээ нь пуужинт цөмийн зэвсгээс эхлээд ердийн зэвсэг, Европ, Ойрхи Дундад, Алс Дорнодыг оруулсан тив дэлхийн өргөн уудам нутгийг хамарсан нөр их ажлын программ болж байна. ЗХУКН-аас дэвшүүлэн тавьсан энэ бүх саналд дэлхийн дэвшилт хүн төрөлхтний ариун нандин хүсэл улс түмнийг цөмийн дайны заналаас ангижруулж, газар дэлхий дээр энх амга-

лан байдлыг сахин хамгаалах, империализм, жанжлал, милитаризмын хүчний эсрэг тэмцлээ үргэлжлүүлж, эгэл хүний хамгийн дээд эрх-амьдрах эрхийг хамгаалахын төлөө боллоцоотой бүхнийг хийе гэсэн нэгдмэл нэгэн зорилго, нийтлэг нэг эрмэлзэл яруу тод тусгагдсан юм.

ЗХУКН-ын хоёр их хурлын хоорондох таван жил энх тайван, ардчилал, нийгмийн дэвшлийн төлөө улс түмний шударга тэмцлийн ялалтын үе, дэлхий дахинд империалист ноёрхлын хүрээ хумигдан багасч, капиталийн орнуудын дотоодын зөрчил, тэдгээрийн хоорондын өрсөлдөөн хурцдаж, империализмын, давын өмнө америкийн империализмын бодлогын түрэмгий шинж чанар илт нэмэгдсэн хатуу ширүүн тэмцлийн үе байлаа. Шударга түмний дайчин тэмцлийг аугаа их Лениний нам, Зөвлөлт төр манлайлж, улс түмний аюулгүй байдал, найрсаг харилцааг бэхжүүлэх үйлсэд манай үеийн улс төрийн гарамгай зүтгэлтэн Л.И.Брежневийн биечлэн оруулсан үлэмж их хувь нэмрийг дэлхийн дэвшилт хүмүүс гүнээ талархан зүй ёсоор үнэлэн сайшааж байна.

Дэлхийн коммунист хөдөлгөөн, үндэсний чөлөөлөх хөдөлгөөн, энх тайвныг эрхэмлэгч хүч нь улс түмний эрх чөлөө, тусгаар тогтнол, хамтын ажиллагааны төлөө тэмцлийн шинэ мөрийн хөтөлбөртэй боллоо. ЗХУКН-ын ээлжит XXVI их хурлын шийдвэрт заасан энх тайванч түүхэн зорилтыг цаашид өргөжүүлэн дэлгэрүүлэх үзэл санаа нь манай гаригийн энх тайвныг эрхэмлэгч сая сая хүний сэтгэл санаанд шинэ их итгэл төрүүлэх нь дамжиггүй.

Аугаа их Октябрийн эх орон, зөвлөлтийн баатарлаг ард түмнийг хүн нийгмийн саруул ирээдүй-коммунизм өөд жар гаруй жилийн турш гарамгай удирдан жолоодсон, олон улсын коммунист хөдөлгөөний дайчин манлай яруу алдарт ЗХУКН-ын ээлжит XXVI их хурлын оновчтой мэргэн шийдвэр нь дэлхий дахины улс түмний амин чухал эрх ашигт үр нөлөөгөө үзүүлэх олон улсын түүхэн ач холбогдолтой юм.

Д. Чулундаваа

ВО ИМЯ МИРА И МЕЖДУНАРОДНОЙ БЕЗОПАСНОСТИ

(Резюме)

XXVI съезд Коммунистической партии Советского Союза явился событием всемирно исторического значения, важнейшим этапом в истории борьбы за мир и социальный прогресс народов.

В Отчетном докладе ЦК КПСС XXVI съезду яркое отражение нашли огромные успехи, которых великий советский народ добился в ходит верный ответ на многие актуальные ключевые вопросы современной экономической стратегию партии и ее миролюбивую внешнюю политику. В этом историческом документе мировое общественное мнение на- ходит верный ответ на многие актуальные ключевые вопросы современной международной жизни. Изложенная в докладе оценка главных тенденций современности, пронизанна историческим оптимизмом, дает полную уверенность в собственных силах тем, кто борется за мир и разоружение, защищает интересы международного рабочего движения, отстаивает независимость и свободу своей родины.

В докладе выдвинуты кардинально новые идеи и важные конструктивные предложения во внешнеполитической области. Они представляют собой органическое продолжение и развитие исторической Программы мира, выдвинутой на XXIV, XXV съездах КПСС.

Новые конструктивные предложения Советского правительства затрагивают поистине широкий круг проблем современного развития между народными отношениями. Они направлены прежде всего на смягчение напряженности в политической и военной сферах, на сохранение мира.

Решения XXVI съезда КПСС получают высокую оценку и единодушное одобрение братских партий, государств и народов социалистического содружества. Политика мира, проводимая СССР и его союзниками, их совместная борьба за разрядку, ослабление угрозы ракетноядерной войны, за свободное и независимое развитие народов стали самым существенным фактором международной жизни.

В то время как Советский Союз неустанно ищет пути и средства для ликвидации очагов напряженности и урегулирования конфликтов в разных частях земного шара, правящие круги США в сговоре с пекинскими гегемонистами нагнетают напряженность, в отношениях с развивающимися странами все более открыто опираются на военную силу. История доказывает, что подобная политика обречена на провал.

Широкая международная общественность, все люди доброй воли требуют от правительств своих стран внимательного изучения и скорейшего претворения в жизнь этих новых крупных инициатив СССР в области внешней политики, направленных на укрепление мира, углубление разрядки, обуздание гонки вооружений и устранение опасности новой мировой войны.